



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 13 өдөр

Дугаар А/44

Улаан-Уул

Шүлхий өвчнөөс урьдчилан
сэргийлэх дархлаажуулалтын ажлыг
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.11, 66 дугаар зүйлийн 66.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6 дахь заалт, Улсын Онцгой комиссын 2022 оны 03 сарын 23-ны өдрийн 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Малын гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг 2022 оны 04 дүгээр сарын 18-ны өдрөөс 05 дугаар сарын 08-ны дотор зохион байгуулсугай.
2. Дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах, хяналт тавих ажлын хэсгийг нэгдүгээр хавсралтаар, дархлаажуулалтын төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Дархлаажуулалтын ажлыг тогтоосон хугацаанд чанартай зохион байгуулж, багийн нутаг дэвсгэр байгаа үхэр сүргийг бүрэн хамруулах, шаардлагатай хашаа хороо, хүн хүчээр хангах, зар мэдээг түргэн шуурхай хүргэж ажиллахыг Багийн Засаг дарга нарт, хариуцсан багийн малд дархлаажуулалтын ажлыг чанартай хийж гүйцэтгэхийг мал эмнэлгийн үйлчилгээний аж ахуйн нэгжийн эмч нарт тус тус үүрэг болгосугай.
4. Дархлаажуулалтын ажилд шаардагдах зардал 1500000 (нэг сая таван зуун мянган) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гарган зарцуулахыг Тамгын газрын дарга (М.Зоригт), нягтлан бодогч (Ч.Батдорж) нарт зөвшөөрсүгэй.

642201063

5. Дархлаажуулалтын ажлын хугацаа, гүйцэтгэлийн чанарт байнгын хяналт тавьж, дүн мэдээг танилцуулж ажиллахыг Мал эмнэлгийн тасаг (О.Намжирмаа)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Засаг даргын орлогч (Г.Баттогтох) нарт тус тус даалгасугай.

ДАРГА



Т.ЭРДЭНЭБАТ

Сумын Засаг даргын 2022 оны
04 сарын 12 ны өдрийн 144
дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт

ЗОХИОН БАЙГУУЛЖ, ХЯНАЛТ
ТАВИХ АЖЛЫН ХЭСЭГ

- 1 дүгээр багт: О.Намжирмаа (Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч)
С.Лувсанцэрэн (Багийн Засаг дарга)
2 дугаар багт: Г.Баттогтох (Засаг даргын орлогч)
Т.Мөнхтогоо (Багийн Засаг дарга)
3 дугаар багт: М.Зоригт (Засаг даргын Тамгын газрын дарга)
Г.Батжаргал (Багийн Засаг дарга)
4 дүгээр багт: Б.Азжаргал (Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн)
Р.Эрдэнэбат (Багийн Засаг дарга)
5, 6 дугаар багт: О.Энхболд (Хөдөө аж ахуйн тасгийн дарга)
С.Гонгор (Багийн Засаг дарга)
Г.Нямдаваа (Багийн Засаг дарга)

-----oO-----

Сумын Засаг даргынны
 04.....сарын 13-ны өдрийн А/44
 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт



МАЛЫН ГОЦ ХАЛДВАРТ ШҮЛХИЙ ӨВЧНИЙ
 ДАРХЛААЖУУЛАЛТЫН АЖЛЫГ ЗОХИОН
 БАЙГУУЛАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

| Д/д | Хэрэгжүүлэх ажил | Хугацаа | Хариуцах эзэн |
|-----|---|---------------------------|-------------------------------|
| 1 | 2 | 3 | 4 |
| 1 | Дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах захирамж гаргах, ажлын хэсгийг томилох | 4 сарын 13 | МЭТ |
| 2 | Вакцинжуулалтанд хамрагдах өрх, малын тооны судалгаа гаргах | 4 сарын 13 | МЭТ, БЗД |
| 3 | Дархлаажуулалтыг зохион байгуулах маршрут зураглалыг нарийвчлан гаргаж мал эмнэлгийн газарт хүргүүлэх | 4 сарын 13 | МЭТ, БЗД |
| 4 | Зарцуулах шатахууны тооцоог гаргаж Засаг даргын нөөц хөрөнгөөс шийдвэрлэх | 4 сарын 14 | ЗДТГ |
| 5 | Гадны аймаг сумд отроор нутаглаж байгаа болон тавиул үхрийн судалгааг гаргаж МЭГ-т хүргүүлэх | 4 сарын 14 | МЭТ |
| 6 | Мал эмнэлгийн нэгдсэн системд шүлхий өвчний дархлаажуулалтын төлөвлөгөөг оруулах | 4 сарын 12- 4 сарын 14 | МЭТ |
| 7 | Шүлхий өвчний вакциныг хадгалах хөргүүрийн ажиллагаа бэлэн байдлыг хангах | 4 сарын 14 | МЭТ |
| 8 | Аймгийн мал эмнэлгийн газраас вакциныг хүлээн авах, коджуулах | 4 сарын 15 | МЭТ-ийн улсын байцаагч |
| 9 | Сумын онцгой комисс, ажлын хэсгийг хуралдуулах | 4 сарын 15 | СОК |
| 10 | Мал эмнэлгийн нэгжийн эмч нарт вакциныг хуваарлах, техник хэрэгслийн бэлэн байдлыг хангах | 4 сарын 15- 4 сарын 17 | МЭТ, МЭҮН |
| 11 | Шүлхий өвчний дархлаажуулалтад баг хариуцсан эмч, ажлын хэсэг гарах | 4 сарын 18 | Ажлын хэсэг, МЭҮН-ийн эмч нар |
| 12 | Мал эмнэлгийн нэгдсэн системд таригдсан малыг газар дээр нь оруулах солиболцлыг тэмдэглэх | 4 сарын 18- 5 сарын 5 | МЭҮН-ийн эмч нар |
| 13 | Тарилгын баримтыг хүлээн авч нэгдсэн системтэй тулгалт хийж хүлээн авах | 5 сарын 1- 5 сарын 5 | МЭТ-ийн улсын байцаагч |
| 14 | Тарилга хийсэн тухай улсын байцаагчийн дүгнэлт, санхүүжилт олгох сумын Засаг даргын албан тоотыг Мал эмнэлгийн газарт хүргүүлэх | 5 сарын 1- 5 сарын 5 | МЭТ-ийн улсын байцаагч |

-----oOo-----